



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 5/65

Хэрлэн сум

Түр орлон гүйцэтгэгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Засгийн газрын 2007 оны "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" тухай 354, 2014 оны "Төрийн зарим албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 75 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Р.Цэцэндэлгэрийг 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн Өлзийт тосгоны ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Захирлын ажлыг хүлээлцэх комисс томилон хүлээлцүүлэхийг тосгоны Захирагч /Д.Алтаннараа/-д даалгасугай.

3. Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдож байгаа Р.Цэцэндэлгэрийн цалинг ТҮБД-н 7-ын 4 дүгээр шатлал 713968 /долоон зуун арван гурван мянга есөн зуун жаран найман/ төгрөгөөр тогтоож, цалинжуулахыг сургуулийн нягтлан бодогч /Г.Баяржаргал/-д зөвшөөрсүгэй.

4. Захирлын ажлыг мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА